# History of the XX Century Mongolia

***1921 REVOLUTION: 3. ESTABLISHMENT OF PARTY OF CLERKS***

LECTURE 7

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

# XX зууны Монголын Түүх

***1921 ОНЫ ХУВЬСГАЛ: 3. ТҮШМЭДИЙН НАМ БАЙГУУЛАГДСАН НЬ***

ЛЕКЦ 7

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## Лекцийн агуулга

- Энэ лекцээр тусгаар тогтнолоо алдах аюулд орсон хүнд үед Ноёдын нам, Түшмэдийн намыг байгуулан тэмцсэн язгууртнууд, сэхээрэлт залуучуудын сэтгэлгээний үнэн түүхийг мэдэж авна.
- Мөн эдгээр намууд Богд хаанаа түшиглэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байсныг мэдэх болно.

Хүрээний буюу Түшмэдийн бүлгэмийн үүслийн он цагийн талаар судлаачид 1918, 1919 онд байгуулагдсан хэмээн харилцан адилгүй санаа оноог дэвшүүлсэн байдаг.

- 1918 оны 5-6 дугаар сард Монгол улсынхаа тусгаар тогтнолыг эргүүлэн авах зорилготой "Тангарагт нөхөд" хэмээх нууц бүлгэм С.Данзангийн санаачлага, Ө.Дэндэв, Д.Догсом нарын оролцоотойгоор анх үүсчээ



https:\\www.mn.m.wikipedia.org

- 1919 оны 11 дүгээр сараас "Тангарагт нөхөд" тэмцлээ эрчимжүүлж арав гаруй түшмэдийг элсүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлснээр "Хүрээний бүлгэм" хэмээн нэрлэгдэх болсон байна



https:\\www.en.m.wikipedia.org

- Данзан, Дэндэв, Догсом нар бүлгэмээ өргөтгөх талаар хэлэлцэж Богд хаанаас дэмжлэг авахаар тогтжээ

- Тэд Богд хаанд өөрсдийн зорилго зорилтоо ойлгуулж чадсанаар хааны шийдвэрээр их шавь зайсан Жамъян, түшмэл Лхайжав, Нямжав, Цэнд, Тогтох, Даш, Галсан, Лхүндэв, Жигмэддорж зэрэг нэр нөлөө бүхий хүмүүс ирж нэгджээ. Сүүлд элссэн гишүүдийн олонхи нь доод хурлын гишүүд байснаараа онцлогтой байлаа.



https://military-history.fandom.com

Богд хаан болон монголын язгуууртнууд гарцаагүй нөхцөлд Орос улсаас тусламж гуйхад хоёр бүлгэм чухал хэмээн үзэж байв.

Тэдний биет төлөөлөгчид Хүрээний болон Консулын бүлгэмийн гишүүдтэй нэг бус удаа уулзаж элчин Орловтой уулзахыг зөвлөж улмаар 1919 оны 10 сарын 17 –ны өдөр түшмэл Жамъянгийн гэрт Орос улсад хандаж тусламжийн бичиг үйлджээ.

Богд хааны ойрын хүн болох Сүхбаатар, Дугаржав, Галсан зэрэг олонд танигдсан нэр бүхий хүмүүс Түшмэдийн намд элсэн оржээ.



https:\\www.unen.mn

Д.Сүхбаатар

Консулын бүлгэмийн талаар Дилав хутагт Жамсранжав “Бодоо хэмээх лам дүрмийн хүн оросын консулынд сууж орос сургагч нарт монгол бичиг зааж байв ... Бодоогийн нөхөр нь цэцэг Шагдар хэмээх хүн лам хар танил олонтой, ... их л олон хүнийг удирдан нийлүүлжээ” гэж дурссан байдаг

(Ариун сэтгэл авралын үндэс, Чойжилсүрэн Л, Интерпресс, 2000, 107)



https\\www.montsame.mn

Дилав хутагт Жамсранжав

# Догсомын Бодоогийн ажиллаж байсан газар



https://military-history.fandom.com

1918 оны сүүлчээр Д.Бодоо, Д.Чагдаржав нар Консулын бүлгэмийг хамтран байгуулжээ.

Консулын бүлгэмийн гишүүд Түшмэдийн бүлгэмд ирж нэгдсэнээр тэдний эгнээ Бодоо, Чагдаржав, Чойбалсан, Лосол, Жигмэд, Намсрай, Алтангэрэл, Бавуу зэрэг сэхээрэлт хүмүүсээр бэхжсэн байдаг.



https:\\www.mn.wikipedia.org



https:\\www.mn.wikipedia.org

Хүрээний болон Консулын бүлгэмүүд аажмаар Түшмэдийн нам болон бэхжив.

Монголд олон намын систем бүрэлдэн тогтох эхлэл тавигдсан байна.

Хүрээнд бүхий оросын хувьсгалчид тэдэнд Ардын нам байгуулахыг санал болгож алсдаа тусламж авахад хялбар болно хэмээн зөвлөжээ.

Ардын нам байгуулах асуудлыг Ноёдын нам, Түшмэдийн нам нэгдсэн хуралдаанаар авч хэлэлцээд:

- Ардын нам байгуулахыг түр азнах
- Орос улс руу Түшмэдийн намаас төлөөлөгчдийг томилж Богд хааны тамгатай бичгийг тэднээр уламжлуулах
- Шаардлагатай тохиолдолд Ардын нам гэсэн хэлбэр төдий модон тамгыг хэрэглэхээр шийдвэрлэв

## References

1. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд, Дашням Г, “Соёмбо принтинг”, 2004

2. Монголд улс төрийн нам байгуулагдсан түүхийн судалгаа (1918-1921), Алтанбагана А, диссертаци, 2015

3. Ариун сэтгэл авралын үндэс, Чойжилсүрэн Л, Интерпресс, 2000

***АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА***